

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1. Оршил.....	3
1.2. Байгаль орчны менежмент төлөвлөгөөний зорилго	3
1.3. Байгаль орчны менежмент төлөвлөгөөний бүтэц.....	3
1.4. Төслийн танилцуулга.....	4
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	7
2.1. Төсөл хэрэгжих орчны цаг уурын нөхцөл	8
2.2. Агаарын чанарын өнөөгийн байдал	9
2.3. Геологийн тогтоц, геоморфологи.....	10
2.4. Гадаргын болон газрын доорх ус	10
2.5. Хөрсөн бүрхэвч	12
2.6. Ургамлын нөмрөг.....	12
2.7. Амьтны аймаг.....	12
3. “ӨЛЗИЙТ ГОЛЫН ХҮЙТЭНИЙ АМНЫ ТОХОЙН ХЭСЭГ” АЛТНЫ ШОРООН ОРДЫН ТЕХНИК-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	12
3.1. 2026 онд хэрэгжүүлэх уулын ажлын төлөвлөгөө, үндсэн үзүүлэлтүүд.....	14
4. ТӨСЛИЙН ДЭД БҮТЭЦ.....	22
4.1. Уурхайн хотхон.....	22
4.2. Холбооны байгууламж	23
4.3. Цахилгаан хангамж	23
4.4. Усан хангамж	23
4.5. Технологийн усны хэрэгцээний тооцоо	24
4.6. Уурхайн усан хангамж.....	24
5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ	24
5.1. БОМТ хэрэгжүүлэх удирдлагын тогтолцоо.....	26
5.2. БОМТ-ний хэрэгжилтийн хяналт	27
5.3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	28
5.4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	29
5.5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	29
5.6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	30
5.7. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	31
5.8. Хог хаягдлын менежмент	31
5.9. БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	33
5.10. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	33
5.11. Тэрбум мод тарих арга хэмжээ	34

Зургийн жагсаалт

Зураг 1. Ордын байршлын зураг.....	5
Зураг 2. Төсөл хэрэгжих нутгийн гадаргын усан сүлжээний зураг.....	11
Зураг 3. Уулын ажлын төлөвлөлт.....	16
Зураг 4. Автосамосвал.....	18
Зураг 5. Хутгуурт ачигч.....	19
Зураг 6. Алттай элсийг баяжуулах технологи.....	21
Зураг 7. Уурхайн хотхоны бүдүүвч зураг.....	23

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Ерөнхий мэдээлэл.....	4
Хүснэгт 2. MV-006853 тоот тусгай зөвшөөрлийн булангийн цэгүүд.....	6
Хүснэгт 3. MV-012413 тоот тусгай зөвшөөрлийн булангийн цэгүүд.....	6
Хүснэгт 4. Техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлт.....	13
Хүснэгт 5. Үйлдвэрлэлийн хүчин чадал, ажиллах горим ба ашиглалтын хугацаа.....	15
Хүснэгт 6. Уулын ажлын төлөвлөлт.....	15
Хүснэгт 7. Үндсэн тоног төхөөрөмж.....	17
Хүснэгт 8. Экскаваторуудын бүтээл, хэрэгцээний тооцоо.....	17
Хүснэгт 9. Автосамосвалын бүтээл, хэрэгцээний тооцоо.....	18
Хүснэгт 10. Баяжуулах хэсгийн технологийн ба ажлын горим.....	20
Хүснэгт 11. Жилд гаргах бүтээгдэхүүний хэмжээ.....	21
Хүснэгт 12. Хаягдлын сангийн үзүүлэлтүүд.....	22
Хүснэгт 13. Технологийн усны хэрэгцээ.....	24
Хүснэгт 14. БОМТ-ний бүрдэл хэсэг, агуулга.....	25
Хүснэгт 15. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал.....	28
Хүснэгт 16. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	29
Хүснэгт 17. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	29
Хүснэгт 18. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ төлөвлөсөн булангийн цэг.....	30
Хүснэгт 19. Түүх-археологийн дурсгалын хадгалалт хамгаалалт.....	30
Хүснэгт 20. Хог хаягдлын төрөл, хэмжээ, устгах хэлбэр.....	31
Хүснэгт 21. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	33
Хүснэгт 22. Орчны хяналт шинжилгээний ажлын төсвийн тооцоо.....	34
Хүснэгт 23. БОМТ-ийн нийт зардлын тооцоо.....	36

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Оршил

Энэхүү 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь “Өлзийт голын Хүйтэний амны тохойн хэсэг” нэртэй алтны шороон ордын ашиглалтын төслийн хүрээнд байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээх, хяналт-шинжилгээ хийх, хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээг тодорхойлсон баримт бичиг болно.

2026 оны уулын ажлын төлөвлөгөөнд алтны шороон ордын 75.86 мян.м³ элсийг угаан баяжуулахаар тусгасан. Элс угаах, баяжуулах ажлыг цагт 80 м³ хүчин чадалтай NZMS80BE маркийн угаах төхөөрөмжөөр гүйцэтгэх бөгөөд төхөөрөмжийг 162 хоног ажиллуулж, хоногт 800 м³ элс боловсруулах боломжтой. Угаах төхөөрөмжийн ашиглалт 70%-иас доошгүй байх нөхцөлд төлөвлөсөн 75.86 мян.м³ элсийг бүрэн угаан баяжуулах хүчин чадал хангалттай байна.

Төслийн хүрээнд шууд болон шууд бус байдлаар нийт 45 хүртэл ажлын байр бий болох бөгөөд уурхайн байнгын үйл ажиллагаанд 19 ажилтан ажиллана. Улс орон нутгийн төсөвт 3023.72 сая.төгрөгийг төвлөрүүлэхээр байна.

1.2. Байгаль орчны менежмент төлөвлөгөөний зорилго

БОМТ-ийн зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах, доройтсон орчныг нөхөн сэргээх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, орчны хяналт-шинжилгээг тогтмол хэрэгжүүлэхэд оршино.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү алтны шороон ордын ашиглалтын төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх ажлын хүрээнд хэрэгжүүлэх хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, нийгмийн асуудал, байгаль орчин, орон нутгийн иргэдийн харилцаа хариуцсан нэгж хэсгүүдийн хамтын ажиллагааг хангасан удирдлага зохион байгуулалтын механизмыг бүрэлдүүлж, хэрэгжүүлэхэд ашиглагдах баримт бичиг юм.

1.3. Байгаль орчны менежмент төлөвлөгөөний бүтэц

Энэхүү Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний аргачлал, Эрсдэлийн үнэлгээ, Эрүүл мэндийн эрсдэлийн тухай, Монгол улсын хууль тогтоомж, Байгаль орчны багц хуулиуд, Монгол улсын стандарт норм, дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэв.

Энэхүү төлөвлөгөө нь:

- Товч танилцуулга, байгаль орчны төлөв байдал, алтны шороон ордын ашиглалтын өнөөгийн байдал
- Алтны шороон ордын ашиглалтын үед үүсэх нөлөөллийн үнэлгээ

■ Алтны шороон ордын ашиглалтын үед үүсэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

■ Төслийн хэрэгжилтийн үед хэрэгжүүлэх арга хэмжээний зардал

■ Байгаль орчин, хөдөлмөрийн хамгааллын аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого ба журам

■ Дагалдах хуудас гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Мөн алтны шороон ордын ашиглалтын үед орон нутгийн иргэдийн амьдралд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээнүүдийг тусгаж өгсөн.

1.4. Төслийн танилцуулга

Төслийн нэр: “Өлзийт голын Хүйтэний амны тохойн хэсэг” алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл.

Төслийн зорилго, ач холбогдол:

“Ододгоулд” ХХК-ний хэрэгжүүлэх “Өлзийт голын Хүйтэний амны тохойн хэсэг” алтны шороон ордыг ил аргаар олборлох төслийн зорилго нь алтны шороон ордын талбайд ашигт малтмал олборлох, болон ашиглалтын явцад байгаль орчинд ээлтэй, хаягдал багатай техник, технологи, тоног төхөөрөмжөөр харилцан ашигтай үйл ажиллагаа явуулах, уул уурхайн салбарт амжилттай ажиллан, Монгол улсын эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулах, ашиглалт, орон нутгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангах, орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний орлого оруулах зэрэгт оршино. Төслийн хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллана. Үүнд:

- Байгаль орчны нөхөн сэргээлт
- Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл багатайгаар үйл ажиллагаа явуулах
- Эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх
- Орон нутгийн оршин суугчдыг ажлын байраар хангах
- Ашигт малтмалыг хаягдал багатайгаар бэлтгэх

Хүснэгт 1. Ерөнхий мэдээлэл


Аж ахуйн нэгжийн нэр	“Ододгоулд” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9019086077
Регистрийн дугаар	5180252
Улсад бүртгүүлсэн	2007.11.20
Үйл ажиллагааны чиглэл	Гадаад худалдаа, Ашигт малтмалын ашиглалт
Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл	MV-006853, MV-012413
Хаяг	Баянхонгор Бөмбөгөр сум, Улаан сайр 1-р баг
Утас	88111691

Төслийн байршил:

Төсөл хэрэгжүүлэгч субъект болох "Ододгоулд" ХХК нь Монгол улсын Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын 1-р багт оршдог.

“Өлзийт голын Хүйтэний амны тохойн хэсэг” алтны шороон орд нь Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумаас баруун хойд зүгт 45км, Улаанбаатар хотоос баруун урд 770км зайд оршино.

ӨЛЗИЙТ ГОЛЫН ХҮЙТЭНИЙ АМНЫ ТОХОЙН ХЭСЭГ" НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫН ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 1. Ордын байрилын зураг

ӨЛЗИЙТ ГОЛЫН ХҮЙТЭНИЙ АМНЫ ТОХОЙН ХЭСЭГ" НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫН
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 2. MV-006853 тоот тусгай зөвшөөрлийн булангийн цэгүүд

ТЗ-ийн дугаар:			MV-006853					
Талбайн нэр:			Өлзийт гол					
Ордын нэр:			Өлзийт голын хүйтэний амны тохойн хэсэг					
Эзэмшигч:			Ододгоулд					
Төрөл:			Ашиглалтын тусгай зөвшөөрөл					
Талбай /га/:			174.21					
Тусгай зөвшөөрлийн талбайн координат								
№	X	Y	Өргөрөг (WGS-84)			Уртраг (WGS-84)		
			град	мин	сек	град	мин	сек
1	5142348.06	535647.64	46	26	1.55	99	27	50.44
2	5142334.74	533300.21	46	26	1.55	99	26	0.44
3	5141409.09	533305.29	46	25	31.56	99	26	0.44
4	5141422.41	535653.07	46	25	31.56	99	27	50.44
5	5141861.32	535650.5	46	25	45.78	99	27	50.44
6	5141889.2	535456.76	46	25	46.72	99	27	41.38
7	5142131.99	534956.37	46	25	54.68	99	27	17.99
8	5142093.17	534644.58	46	25	53.48	99	27	3.37
9	5141975.91	534487.1	46	25	49.71	99	26	55.96
10	5141842.62	534332.69	46	25	45.42	99	26	48.69
11	5141770.71	534005.27	46	25	43.14	99	26	33.34
12	5141914.53	533836.29	46	25	47.84	99	26	25.45
13	5142039.57	533786.93	46	25	51.9	99	26	23.17
14	5142087.91	533654.35	46	25	53.49	99	26	16.97
15	5141965.57	533466.36	46	25	49.56	99	26	8.13
16	5141906.95	533303.41	46	25	47.7	99	26	0.48
17	5142040.6	533302.68	46	25	52.02	99	26	0.48
18	5142166.67	533495.13	46	25	56.07	99	26	9.53
19	5142207.8	533676.94	46	25	57.37	99	26	18.06
20	5142081.06	534031.07	46	25	53.2	99	26	34.62
21	5142053.77	534283.7	46	25	52.27	99	26	46.45
22	5142164.51	534434.81	46	25	55.83	99	26	53.56
23	5142248.99	534634.51	46	25	58.53	99	27	2.94
24	5142274.15	534985.64	46	25	59.28	99	27	19.4
25	5142251.69	535105.71	46	25	58.53	99	27	25.02
26	5142164.78	535182.62	46	25	55.7	99	27	28.6
27	5142017.04	535518.33	46	25	50.85	99	27	44.29
28	5142000.52	535649.68	46	25	50.29	99	27	50.44

Хүснэгт 3. MV-012413 тоот тусгай зөвшөөрлийн булангийн цэгүүд

ТЗ-ийн дугаар:			MV-012413					
Талбайн нэр:			Өлзийт гол					
Ордын нэр:			Өлзийт голын хүйтэний амны тохойн хэсэг					
Эзэмшигч:			Ододгоулд					
Төрөл:			Ашиглалтын тусгай зөвшөөрөл					
Талбай /га/:			472.3					
№	X	Y	Өргөрөг (WGS-84)			Уртраг (WGS-84)		
			град	мин	сек	град	мин	сек

**ӨЛЗИЙТ ГОЛЫН ХҮЙТЭНИЙ АМНЫ ТОХОЙН ХЭСЭГ" НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫН
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

1	5142705.7	537779.5	46	26	12.73	99	29	30.44
2	5142765.2	537719.4	46	26	14.66	99	29	27.64
3	5142976.7	537571.5	46	26	21.54	99	29	20.77
4	5142945.5	532016.5	46	26	21.56	99	25	0.44
5	5142636.8	532018.2	46	26	11.56	99	25	0.44
6	5142643.7	533298.5	46	26	11.56	99	26	0.44
7	5142334.7	533300.2	46	26	1.55	99	26	0.44
8	5142348.1	535647.6	46	26	1.55	99	27	50.44
9	5141422.4	535653.1	46	25	31.56	99	27	50.44
10	5141434.7	537787.4	46	25	31.54	99	29	30.44
11	5141863.4	537784.8	46	25	45.43	99	29	30.44
12	5141736.2	537633.8	46	25	41.34	99	29	23.33
13	5141657.9	537492.6	46	25	38.83	99	29	16.69
14	5141552	537186.9	46	25	35.46	99	29	2.34
15	5141516.8	537042.4	46	25	34.35	99	28	55.56
16	5141493.3	536874.2	46	25	33.62	99	28	47.67
17	5141451.7	536733.3	46	25	32.3	99	28	41.05
18	5141429.3	536706.6	46	25	31.58	99	28	39.8
19	5141427.1	536332.7	46	25	31.58	99	28	22.28
20	5141451.5	536233.7	46	25	32.39	99	28	17.65
21	5141543.9	536095.7	46	25	35.41	99	28	11.21
22	5141702.4	535925.7	46	25	40.58	99	28	3.29
23	5141711.2	535837.7	46	25	40.88	99	27	59.18
24	5141811.7	535768.2	46	25	44.15	99	27	55.94
25	5141861.3	535651.1	46	25	45.77	99	27	50.47
26	5142003	535650.3	46	25	50.36	99	27	50.47
27	5141966.5	535842.4	46	25	49.15	99	27	59.46
28	5141798.3	536104.8	46	25	43.65	99	28	11.71
29	5141682.7	536195.2	46	25	39.88	99	28	15.91
30	5141637.2	536369.4	46	25	38.38	99	28	24.06
31	5141523.1	536497.1	46	25	34.66	99	28	30.01
32	5141628.2	536781.2	46	25	38.01	99	28	43.34
33	5141690.5	537124.8	46	25	39.97	99	28	59.47
34	5141768.7	537298.5	46	25	42.46	99	29	7.63
35	5141798.7	537458.4	46	25	43.4	99	29	15.13
36	5141907	537644.5	46	25	46.87	99	29	23.88

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

“Ододгоулд” ХХК -ний “Хүйтэний амны тохойн хэсэг” алтны шороон орд нь манай орны төвийн районы Хангайн уулсын хэсэгт Өлзийт голын хөндийд оршино. Өлзийт голын татам дэнж газарт байрлана.

Ордын талбай орчмын хамгийн өндөр цэг нь далайн түвшнээс дээш 2245.0 м өндөрт өргөгдсөн Цогт хайрхан уул, хамгийн нам цэг нь 1657 м Өлзийт- Байдрагийн бэлчрийн татам юм.

Орд орчимд уулархаг, хэрчигдэл ихтэй, уулын үнэмлэхүй өндөр нь далайн түвшнээс дээш 1506.0-2245.0 м, өндрийн зөрүү 600-700 м хүрдэг. Өлзийт гол нь тохойрол ихтэй, гол төлөв хавцлуудаар урсдаг, хадан хясаа, өндөр дэнжүүдтэй, голын хөндий нь 0.5-0.8 км өргөн, булан тохой их, уулархаг гадаргатай. Ордын район эх газрын эрс тэс уур амьсгалтай, Өлзийт голын эх орчим нь өндөрлөг тул эрт сэрүүсэж, өвөл хүйтэн, цас их ордог онцлогтой.

Өлзийт гол нь Төв Азийн Гадагш урсгалгүй ай савд хамаарагдах Бөөнцагаан нуур Байдраг голын сав газарт буюу Хойд талд Хан Хөхий, Тарвагатай, Булнай зэрэг өндөр нурууд өргөргийн дагуу буюу баруун ам зүүн тийшээ сунаж салбарлана. Хангай нурууны өврийн Буга, Нарийнтээл, Мандал голуудын бэлчир орчмоос Байдраг нэртэй болох ба Өлзийт, Заг, Цагаантуруут гол түүнд цутгаж урссаар Бөөнцагаан нуурт цутгана. Хангайн өмнөд хажуугаас эх авч говийн Бөөнцагаан, Адгийн цагаан хоёр нуурт усаа нийлүүлдэг энэ голын нийт урт Бөөнцагаан нуур хүртэл 295 км, Адгийн цагаан нуур хүртэл 310 км талбайгаас усжина. Байдраг голын эхэнд баруун гар талаас Загийн гол /80 км/, зүүн гар талаас Өлзийтийн /135 км/ гол тус тус цутгадаг, голын дагууд урсац нь 2.8 шоо м/сек болно.

2.1. Төсөл хэрэгжих орчны цаг уурын нөхцөл

Баянхонгор аймаг нь 116.0 мянган дөрвөлжин километр нутагтай, далайн түвшнээс дээш 974-2435 м хүртэл өндөр өргөгдсөн, газар нутгийн хотгор гүдгэрийн ялгаа ихтэй зэрэг нь агаарын температур, хур тунадасны газар зүйн хуваарилалтад ихээхэн нөлөөлж бүс нутгийн хувьд жил, сарын температур, хур тунадас жигд биш байдаг билээ.

Агаарын температурын горим

Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт уур амьсгалын дунджаар /1985-2016/ жилийн дундаж температур нутгийн хойд хэсгээр -4.1-ээс -7.5 градусын хүйтэн, төвийн хэсгээр 0.0 градус байхад өмнөд хэсэгт 2.8-аас 8.8 хэмийн дулаан байгаа нь дулаан хүйтний хэлбэлзэл ихтэйг илтгэнэ.

Тус аймгийн өмнөд хэсэг нь Азийн хуурай, хуурайдуу говь цөлийн бүсэд багтдаг бөгөөд хамгийн халууны туйл болдог юм. Аймгийн нийт нутаг дэвсгэрт агаарын үнэмлэхүй их температур 7 сард тохиодог. Температур хуваарилалтаар нутгийн хойд хэсэг болон алтай салбар ууланд орших хэсэгт 28.1-ээс 31.8 градус, төвийн хэсэгт 31.0-ээс 36.6 градус өмнөд хэсэгт 38.8-аас 44.9 градус дулаан байдаг. Шинэжинст сумын Эхийн гол өртөөнд 1992 оны 07 дугаар сард 44.9 хэм хүрсэн бөгөөд энэ утга Монгол орны үнэмлэхүй хамгийн дулаан нь байжээ.

Баянхонгор аймгийн нутагт жилийн дулааны улиралд болох 4-10 сард нийт орох хур тунадасны 90-94% нь ордог нь Монгол орны хур тунадасны горим манай аймаг тод илэрдэг. Тогтвортой цаг агаар ноёлох өвлийн /11-3 сар/ улиралд аймгийн нийт нутгаар уур амьсгалын дунджаар 4.9-өөс 14.6 мм хур тунадас орох бөгөөд 1, 2 сард 0.4- өөс 3 мм орчим унадаг.

Салхины горим

Салхины горим нь агаар мандлын орчил урсгал, тухайн орон нутгийн уул зүйн онцлогоос хамаарна.

Салхины чиглэл: Баянхонгор аймгийн нутагт Монгол орны бусад нутгийн адил хойд, баруун хойд чиглэлийн салхи голчлон давтагддаг. Салхины зохиолох чиглэл улирал сар бүрд нутгийн онцлогоос болж өвөрмөц боловч салхины ерөнхий горим хадгалагдаж байдаг. Судалгааны үр дүнгээр харахад: Өвлийн улиралд баруун хойноос 27.3 хувь, хойноос 24.8 хувь, баруунаас 6.2 хувь зүүн хойноос 9 хувь, салхигүй үеийн давтагдал 20.2 хувь байгаагаас харахад баруун хойд болон хойд чиглэлийн салхи ноёлж байна.

Зуны улиралд салхины зонхилох чиглэлийн давтагдал нь баруун хойноос 17.5 хувь, баруунаас 16 хувь, хойноос 9.7 хувь, бусад бүх чиглэлээс 7 хувь, салхигүй үеийн давтагдал 20.6 хувь байдаг.

Намрын улиралд салхины зонхилох чиглэл нь баруун хойноос 28.0 хувь, баруунаас 16 хувь, хойноос 15.4 хувь, зүүн хойноос 4.0 хувь, салхигүй үеийн давтагдал 12.6 хувь байгаа нь хаврын улиралтай ойролцоо давтагдалтай байна.

Гэвч орон нутгийн онцлогоос шалтгаалан өвөрмөц байдал илэрдэг. Жилийн дундаж байдлаар Баянхонгор суманд баруунаас 7.9%, баруун хойноос 22.8%, давтагдалтай салхины ерөнхий горим илэрдэг боловч Түйн голын сав дагуу зүүн хойноос 38.3% илүү давтагдалтай байгаа нь орон нутгийн онцлог байдлын жишээ юм.

Салхины хурд: Баянхонгор аймгийн салхины жилийн дундаж хурд уур амьсгалын дунджаар говийн нутгаар 3.4 м/с, тал хээрийн нутгаар 2.8 м/с, хангай уулархаг нутгаар 2.0 м/с байдаг.

Шороон шуурга: Салхины хурд, хөрсний байдалтай уялдан шороон шуургатай өдрийн тоо түүний эрч хүч газар бүр харилцан адилгүй байдаг. Жилд дунджаар хангай бүсийн нутгаар 25 өдөр, тал хээрийн бүсийн нутгаар 34 өдөр, говийн бүсийн нутгаар 38 өдөр шороон шуургатай байдаг.

2.2. Агаарын чанарын өнөөгийн байдал

Төслийн хүрээнд боловсруулсан арга зүйн дагуу төслийн талбайг төлөөлж чадахуйц 6 цэгээс нийт тоос буюу TSP-ийн дээжийг 30 минутын туршид 2 удаа, хүхэрлэг хий (SO₂) болон азотын давхар исэл (NO₂) 20 минутын туршид 2 удаа нийт 12 удаагийн хэмжилтийг хийнэ.

Нийт тоосыг лазер гэрлийн сарнилын автомат багажаар тодорхойлсон бөгөөд энэ аргын үндэс нь агаараас сорьцыг сорох төхөөрөмжийн тусламжтайгаар лазер гэрлийн үүсгүүр бүхий оптик системээр нэвтрүүлэхэд лазер гэрлийн сарнимал тухайн агшинд оптик систем дундуур өнгөрч буй сорьц дахь тоосны агууламжтай шууд хамааралтай байдаг аргад үндэслэгдэнэ. Хүхэрлэг хий (SO₂)-г фотоколорометрийн аргаар тодорхойлсон. Энэ арга нь агаар дахь хүхэрлэг хийг тетрахлормеркурат натрийн уусмал /ТХМ/-аар норгосон шингээгч гуурсны шилэн бөмбөлгийн давхаргад шингээж авна. Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторийн агаарын чанарын итгэмжлэгдсэн лабораторид шингээж авсан хүхэрлэг хийг уусмал байдалд шилжүүлж, тухайн уусмал

дээрээ формальдегид, парарозанадины уусмал нэмэхэд үүссэн нэгдлийн өнгөний эрчимжлээр хүхэрлэг хийг тодорхойлно. Шинжилж байгаа сорьцод энэ аргаар 0.1мкг-аас багагүй хүхэрлэг хийг илрүүлдэг.

2.3. Геологийн тогтоц, геоморфологи

Давхарга зүй

Архей-рифейн настай тоналит-гнейс, амфиболит, талст занар, кварцит, мигматит, гантиг, шохойн чулуу зэрэг хувирмал хурдсаас бүрдэнэ.

Гүний чулуулаг

Хайгуулын талбайд бага тархсан, зөвхөн дээд палезойн настай Байдрагийн комплекс гэж ялгагдсан том ширхэгтэй, цайвар шаргал өнгөтэй боржин тархсан байдаг. Энэ боржин нь Байдрагийн гүүрний орчим мөн Өлзийт голын бэлчирт тархалттай. Хар занар Байдраг, Өлзийт голын бэлчрээс дээш Уртын голын адаш, Шорвогт голын бэлчир, Өлийн даваа, Хөх сайр, Дааган дэлийн нурууны зүүн хойгуур Бүрдийн гол орчимд кварц, пиритээр баяжсан, алт 5-15 км заримдаа түүнээс ч өргөн, 400 гаруй км баруун зүгт үргэлжилдэг.

Төслийн талбайн тектоник

Тектоник бүтэц нь зүүн хойноосоо баруун урагш чиглэлд хагарлаар заагласан. Загийн серийн ногоон занарын флиш, офиолит эвшил, хар занар, тоналит гнейсийн харилцан өөр настай геологийн формацуудаас бүтсэн бүслүүрлэг, нэлээд их өөрчлөгдсөн нийлмэл тогтоцтой Баянхонгорын систем хагарлын бүс болно.

Төслийн талбайн геоморфологи


Өлзийтийн алтны шороон орд нь манай орны төвийн районы Хангайн уулсын хэсэгт Өлзийт голын хөндийд орших бөгөөд засаг захиргааны нэгжийн хувьд Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутаг дэвсгэрт хамаарагдана.

2.4. Гадаргын болон газрын доорх ус

Гадаргын усны төлөв байдлын суурь үнэлгээ

Төслийн хүрээнд байгуулагдах ил уурхайнуудын сөрөг нөлөөлөлд тухайн газарт ойролцоо орших Өлзийт голд бага зэргийн сөрөг нөлөөлөлд өртөхөөр байна. Уурхайн баяжуулах үйлдвэрт хэрэглэх 6.88л/с усыг Өлзийт голоос татна. Өлзийт голын усны урсац, түвшнийг байнгын хэмжих зорилгоор ус судлын түр харуул байгуулах. Уурхайн хэрэглээнд хэрэглэгдэх усыг авч байгаа шугам хоолойн дээд болон доод талд усны урсац болон түвшингийн байнгын хэмжилт хийнэ.

Ус зүйн муж: Төв Азийн гадагш урсгалгүй ай сав



Зураг 2.Төсөл хэрэгжих нутгийн гадаргын усан сүлжээний зураг

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт задгай урсгал ус байхгүй бөгөөд ойр орших томоохон гол, мөрөн нь Байдраг гол юм. Байдраг гол нь Хангай нурууны өврийн Буга, Нарийнтээл, Мандал голуудын бэлчир орчмоос Байдраг нэртэй болох ба Заг, Цагаантуруут гол түүнд цутгаж урссаар Бөөнцагаан нуурт цутгана. Мөн ус их үед Адгийн цагаан нуурт цутгах бөгөөд харин ус багатай үед газрын доогуур шургана. Голын ус хурах талбай 18226 ам км, 310 км урт юм. Байдраг гол Хангай нурууны өврийн голуудын нэгэн адил голын дагууд урсац нь алдагдаж, газрын доорх урсацыг тэтгэн Нууруудын хөндийн нууруудад цутгадаг онцлогтой.

Эргийн хамгаалалтын бүс

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутагт орших MV-006853, MV-012413 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл нь "Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай" хуулийн 4.3 -т заасан Засгийн газрын 2012 оны 194 дүгээр тогтоолоор баталсан /Засгийн газрын 2015 оны 289 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон/ усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүстэй хэсэгчилсэн давхцалтай байна. Усны тухай хуулийн 22.2 -т заасан онцгой хамгаалалтын бүстэй давхцалгүй, Засгийн газрын 2015 оны 120 дугаар тогтоолын 2.5, 2.8 -д заасан шаардлага хангасан байна (MV-006853 MV-012413 тоот талбайн зөвшөөрлийг хавсаргав).

Газрын доорх усны төлөв байдлын суурь үнэлгээ:

Уурхайгаас гарах $345.8\text{ м}^3/\text{х}$ шүүрлийн усыг шавхан зайлуулж баяжуулах үйлдвэрт хэрэглэнэ. газрын доорх усны түвшин болон чанарын хэмжилтийг тогтмол хийх зорилгоор газрын доорх усны урсгалын дээд талд 1 цооног, доод талд 2 цооног тус бүр 10м-н гүнтэй байгуулах.

2.5. Хөрсөн бүрхэвч

Талбайн хэмжээнд Чулуурхаг Хүрэн хөрс зонхилох талбайд тархсан бөгөөд Сайргархаг Хүрэн, Аллювийн бараан, Сайрын хайргархаг хөрс тус тус тархсан байна. Хөрсний элэгдэл эвдрэл: талбайн хэмжээнд уурхайн үйл ажиллагаагаар нийт 91.4 га талбай эвдрэлд орсон байна. Энэ нь нийт талбайн 41.8 хувьтай тэнцэх хэмжээ юм.

2.6. Ургамлын нөмрөг

Ургамлын аймгийн зүйлийн бүрдлийн хувьд шороон орд орчмын ургамалжилтад хуурай бүс нутагт зонхилон тархдаг төлөөлөгчдөөс бүрдсэн 13 овогт хамаарах 26 төрлийн 40-аад зүйлийг бүртгэв. Амьдралын хэлбэрийн сөөг 2 зүйл (5.5%), заримдаг сөөгөнцөр 4 (11%), цөөн наст 8 (21.5%) гэсэн хэлбэрүүдээс 23 зүйл олон наст өвс 62.0%-иар, экологийн хуурайсаг, чулуулаг-хуурайсаг, чулуулаг, элслэг, бүлгүүдэд хуваарилагдах ба чийгсүү-хуурайсаг 11 зүйл (29.7%), хуурайсаг бүлгийн 20 зүйл 54 %-иар тус тус давамгайлна.

Ховор ургамал ба бэлчээр тэжээлийн ач холбогдолтой ургамал. Нийт талбайн хэмжээний ургамлын зүйлийн бүрэлдэхүүнд Монгол Улсын Байгалийн Ургамлын тухай хуулийн “Ховор” ургамлын жагсаалтад орсон Ацан Ажигана, Сарвуун Сонгино гэх зэрэг 2 зүйл бүртгэгдэв.

Ургамлын нөмрөг мөхөж ургамлын бүлгэмдэл өөр ургамал бүлгэмдлээр солигддог. Энэ үйл явц нь олон жил үргэлжилдэг ба зарим үед эргэлт буцалтгүй явагддаг учраас дээрх бэлчээр тэжээлийн үнэт ургамлын нөхөн сэргээлтийн ажлыг зайлшгүй хийх шаардлагатай.

2.7. Амьтны аймаг

Бидний судалгаагаар хөхтөн амьтны бор туулай, үлийн цагаан оготно, урт сүүлт зурам гэх 3 зүйл тохиолдов. Монгол тарваганы ухаж гаргасан овоорч дагтаршсан дош тохиолдсон. Дээрх бүх цэгүүдэд үлийн цагаан оготны үүр м² талбайд 7-9 ширхэг тоологдов. Энэ бүс нутаг хөрсний бүтцээс хамаарч бэлчээрийн доройтолд өртсөн байв. Өлзийт голын усны шувууд, Хүйтэний хөндийн ойр орчмын нутагт тохиолдол нийт 10 зүйлийн шувууд бүртгэгдэв. Бүртгэгдсэн шувууд анхааралд өртөөгүй зүйлүүд байв. Бидний судалгаагаар 10 зүйлийн шувуу тэмдэглэгдсэн нь Улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцын хавсралтад бүртгэгдээгүй байна. Хондон ангир өвөлждөг, үрждэг, элбэг зүйл юм.

3. “ӨЛЗИЙТ ГОЛЫН ХҮЙТЭНИЙ АМНЫ ТОХОЙН ХЭСЭГ” АЛТНЫ ШОРООН ОРДЫН ТЕХНИК-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

АМГТХЭГ-ын даргын 2012 оны 4 дүгээр сарын 17-ны 74 тоот тушаалаар батлагдсан “Уул уурхайн төслийн техник эдийн засгийн үндэслэлд тавигдах шаардлагууд ба техник эдийн засгийн үндэслэл хүлээн авах тухай заавар”-г мөрдлөг болгожээ.

ӨЛЗИЙТ ГОЛЫН ХҮЙТЭНИЙ АМНЫ ТОХОЙН ХЭСЭГ" НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫН
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 4. Техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд		Тодорхойлолтууд	
1	Аж ахуй нэгжийн нэр		Ододгоулд	
2	Улсын бүртгэлийн дугаар		9019086077	
3	Ордын нэр ба тусгай зөвшөөрлийн дугаар		Өлзийт голын Хүйтэний амны тохойн хэсэг MV- 006853, MV-012413	
4	Ордын геологийн батлагдсан (B+C) нийт нөөц МУ-006853,МУ-012413	Алт агуулсан элс(B+C)	мян.м ³	236.9
		Дундаж агуулга	мг/м ³	413.2
		Алт, /шлихээр/	кг	97.86
		Алт, /хими/	кг	87.87
5	2022-2024 онд олборлосон нөөц	Алт агуулсан элс(B+C)	мян.м ³	43.6
		Дундаж агуулга	мг/м ³	263.1
		Алт, /шлихээр/	кг	11.46
		Алт, /хими/	кг	10.49
6	2024.01.01-ний байдлаарх үлдэгдэл нөөц	Алт агуулсан элс(B+C)	мян.м ³	193.3
		Дундаж агуулга	мг/м ³	446.9
		Алт, /шлихээр/	кг	86.38
		Алт, /хими/	кг	77.39
7	Ил уурхайн хүрэн дэх ашиглах нөөц	Алт агуулсан элс(B+C)	мян.м ³	191.4
		Дундаж агуулга	мг/м ³	263.1
		Алт, /шлихээр/	кг	85.5
		Алт, /хими/	кг	76.1
8	Ашиглалтын үеийн хаягдал	1%	мян.м ³	1.93
			кг	0.85
9	Бохирдолт		%	35.8
10	Нэмэгдэх хөрс		мян.м ³	8.97
11	Үйлдвэрлэлийн нөөц	Алт агуулсан элс(B+C)	мян.м ³	259.8
		Хөрс	мян.м ³	707.25
		Дундаж агуулга	мг/м ³	329.2
		Алт, /шлихээр/	кг	85.5
		Алт, /хими/	кг	76.1
12	Хөрс хуулалт		мян.м ³	707.25
13	Уурхайн жилийн хүчин чадал		мян.м ³	78
14	Ашиглалтын хугацаа		жил	4
15	Ашиглалтын систем		Дотоод овоолготой, авто тээвэртэй ашиглалтын систем	
16	Ажиллах горим	жилд ажиллах хоног	хоног	162
		хоногт ажиллах ээлж	ээлж	2
		ээлж үргэлжлэх хугацаа:	цаг	10
17	Ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд	Экскаватор Hyundai R480LC-9S-1ш		
		Экскаватор Hyundai R300LC-1ш		
		Хутгуурт ачигч -1ш		
		Автосомасвал -2ш		
18	Ажлын доголын өндөр		3-4м	
19	Доголын налууугийн өнцөг		65 градус	
20	Ажлын талбайн хамгийн бага өргөн		20м	

**ӨЛЗИЙТ ГОЛЫН ХҮЙТЭНИЙ АМНЫ ТОХОЙН ХЭСЭГ" НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫН
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

21	Замын налуу		80 промилле
22	Элс угаах тоног төхөөрөмж		Screen NZMS80BE
23	Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал		199.9 мян.м3/жил
24	Баяжуулах арга		Гравитац
25	Металл авалт		90.24%
26	Баяжмал дахь алт (шлихээр)		
27	Баяжмал дахь алт (хими цэвэр)		
28	Голын сав газар		Бөөнцагаан нуур-Байдраг гол
29	Технологи шаардлагатай усны хэмжээ	мян.м ³ /жил,	1039.2
30	Эргэлтийн ус 70%	мян.м ³ /жил,	727.5
31	Технологийн цэвэр 30%	мян.м ³ /жил,	311.8
32	Шүүрлийн ус	мян.м ³ /жил,	215.5
33	Гадаргын ус	мян.м ³ /жил,	96.3
34	Ахуйн хэрэглээ	мян.м ³ /жил,	1.2
35	Зам талбайн тоосжилт дарахад ашиглах ус	мян.м ³ /жил,	5.2
36	Цахилгаан хангамж		Өөрийн эх үүсвэр генератор
37	Дизель станц Баяжуулах хэсэгт	КС70СГ	2ш
38	Дизель станц Тосгон болон засварын хэсэгт	КС50СГ	2ш
39	Ажиллагсдын тоо		хүн 19
40	Нийт зардал		сая.төг 2064.02
41	Алтны бүрэн өөрийн өртөг	кг	мян.төг
		гр	мян.төг
		унц	мян.төг
42	Алтны борлуулах үнэ	кг	мян.төг
		гр	мян.төг
		унци	мян.төг
43	Борлуулалтын орлого		сая.төг 5922.5
44	Цэвэр ашиг		сая.төг
45	Нийт хөрөнгө оруулалт		сая.төг 1500
46	Хөрөнгө оруулалт нөхөн төлөх хугацаа		жил 0.6
47	Улсын төсөвт оруулах хөрөнгө		сая.төг 792.32
48	Ашгийн дотоод норм IRR		% 95%
49	NPV 10%		сая.төг 1,373.10

3.1. 2026 онд хэрэгжүүлэх уулын ажлын төлөвлөгөө, үндсэн үзүүлэлтүүд

Уурхайн талбайн нээлт

Уурхайн нээлт нь нөөцийн 16В блокоос 4С блок хүртэл буюу татам хэсгийн нөөцийг бүхэлд нь хамруулан явагдана. Уурхайг траншей нэвтрэхгүйгээр 16В блокийн урд хэсгээс хуучин мөрөгцөгийг үргэлжлүүлэн нээнэ.

Нээх блокийн үржил шимт өнгөн хөрсийг экскаватороор хуулж, уурхайн хилийн гадна тодорхой зайд хуримтлуулна.

Хүснэгт 5. Үйлдвэрлэлийн хүчин чадал, ажиллах горим ба ашиглалтын хугацаа

Үзүүлэлт	5	6	7	8	9	10	Нийт
Хуанлийн хоног	31	30	31	31	30	31	184
Амралтын хоног		1	6				7
Урсгал засвар	3	3	3	3	3	3	18
Цаг агаарын хүндрэл	2					2	4
Сард ноогдох ажлын хоног	26	27	28	28	27	26	162
Баяжуулалт	26	27	28	28	27	26	162

Ашиглалтын систем

Уурхайлалтаар 2026 оны 05-р сарын 01-ээс 11-р сарын 01-ний өдрийн хугацаанд нийт 4 ухааш үүсэх бөгөөд татмын хэсгийн 16-блокийг ухааш-1, дэнжийн хэсэгт хамаарах 2С, 4В гэсэн нөөцийн блокуудыг ухааш-2, 6В блокийг ухааш-4, 4С блокийг ухааш-5 -д тус тус харьяалуулан дугаарласан байна. Дэнжийн хэсгийн уст үе нь газрын гадаргаас 6-10 м -ээс эхлэх бол татам хэсгийн уст үе нь газрын гадаргаас 1 м -ээс хэтрэхгүй гүнээс эхэлнэ. Хайгуулын ажлын үед ухсан шурфээс шавхалт хийж үзэхэд 20л/сек хүртэл ундаргатай байх төлөв ажиглагдсан байна.

Ерөнхийдөө ордыг ил аргаар, экскаватор, автосамосвалийн хослол бүхий дотоод овоолготой ашиглалтын системээр ашиглахаар төсөлд тусгав. Дэнжийн хэсгийг ашиглахад харьцангуй хялбар байх бөгөөд устай холбоотой хүндрэл олборлолтын явцад гарахгүй.

Уурхайн параметр:

- Уурхайн хажуугийн налууугийн өнцөг - 70⁰-75⁰
- Доголын өндөр - 4 м хүртэл
- Доголын налууугийн өнцөг - 70⁰-75⁰
- Үржил шимт хөрсний овоолгын дундаж өндөр - 5 м
- Овоолгын налуу - 45⁰

2026 оны уулын ажлын төлөвлөлт

Хүснэгт 6. Уулын ажлын төлөвлөлт

Үзүүлэлт		Хэмжих нэгж	2026
Аль хэсэг			Татам + Дэнж
Ухашийн дугаар			Ухаш-1, Ухаш-2, Ухаш-4, Ухаш-5
Блокын дугаар			2С, 4С, 4В, 6В, 16В
Шимт хөрс		мян.м ³	179.97
Хөрс хуулалт		мян.м ³	199.8
Элс олборлолт	В	мян.м ³	54.48
	С	мян.м ³	2.66
	В+С	мян.м ³	57.14
Металл /шлих/	В	кг	20.57


ӨЛЗИЙТ ГОЛЫН ХҮЙТЭНИЙ АМНЫ ТОХОЙН ХЭСЭГ" НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫН
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	С	кг	1.57
	В+С	кг	22.14
Агуулга	В	мг/м ³	≈751
	С	мг/м ³	≈1755
	А В+С	мг/м ³	

2026 он: XV-012413-ийн дэнжийн хэсгийн 2С, 4В, 6В, 4С, XV-006853-ийн үлдэгдэл хэсэг болох татмын хэсгийн 16-В нөөцийн блокуудыг зүүн захаас нээнээр ухааш-1 бий болж, 179.97 мян.м³ үржил шимт хөрсийг 16-В блокийн баруун талд шимт хөрсний овоолгын талбайд овоолж, 17.31 мян.м³ хоосон чулуулгийг ил уурхайн дотоод овоолгонд, ухашийн хойд хил дагуу 85 м-ийн хамгаалалтын зай баримтлан урагш чиглэлд үе шаттайгаар шахаж овоолно

Ингэснээр дотоод овоолгоор дүүргэгдээгүй үлдэх хоосон орон зайг технологийн зориулалттай ус хуримтлуулах талбай болгон ашиглах нөхцөл бүрдэх бөгөөд татмын хэсгийн 16-В нөөцийн блокоос ашиглах боломжтой 63.08 мян.м³ алт агуулсан элсэнд баяжуулалт хийж, 17.31 кг хүртэлх химийн цэвэр алт олборлох боломж бүрдэнэ.

Дэнжийн хэсэгт хамаарах 2-С, 4-С, 4-В, 6-В нөөцийн блокуудыг ашиглахад нийт 19.2 мян.м³ үржил шимт хөрс, 10.49 мян.м³ хоосон чулуулаг үүсэх бөгөөд үржил шимт хөрсийг тусгай түр овоолгод хадгалж, хоосон чулуулаг үүсэх бөгөөд үржил шимт хөрсийг тусгай түр овоолгод хадгалж, хоосон чулуулгийг ил уурхайн дотоод овоолгоор урагш шахан байршуулна. Эдгээр блокоос нийт 4.83 кг химийн цэвэр алт олборлохоор тооцоолсон.



Зураг 3. Уулын ажлын төлөвлөлт

Тоног төхөөрөмжийн сонголт

Хүснэгт 7. Үндсэн тоног төхөөрөмж

Тоног төхөөрөмж	Марк	Тоо
Уулын хэсэг		
Экскаватор	Hyundai R480LC-9S	1
Экскаватор	Hyundai R300LC	1
Бульдозер	Shantu-TY230B	1
Автосамосвал	Howo sinotruck	4
Баяжуулах хэсэг		
Шинэ зеаланд скруббер	NZMs80BE	1
Баяжуулах ширээ	CKM-1A	1
Насос	4PNJA	2
Дизель генератор	KC70GF	1
Дизель генератор	KC50	1
Хуггуурт ачигч	ZL50	1

Ухаж ачих ажиллагаа

Ордын геологийн тогтоц нь энгийн, голын татмын хэсэгт дунджаар 3.0 м гүнд байгаа учир хөрсийг экскаватор автосамосвалын хослолоор хуулж, элсийг олборлоно. Уурхайд ажиллах ухаж ачих төхөөрөмжөөр одоо компанийн эзэмшилд байгаа төхөөрөмжүүдийг ажиллуулна.

Хүснэгт 8. Экскаваторуудын бүтээл, хэрэгцээний тооцоо

Үзүүлэлтүүд	Нэгж	-	-
Орлын өргөн	м	18.00	20.0
Экскаваторын бүтээл	м ³ /цаг	83.0	180.0
Экскаваторын утгуурын багтаамж	м ³	1.19	2.27
Мөчлөгийн хугацаа	сек	30	25.0
Экскавацийн коэффициент	Кэ	0.96	0.96
Мөргөцөг дэх ахилт шилжилтийг тооцох коэф	Кма	0.95	0.9
Мөргөцгийн нөхцөлийг тооцох коэф	Км	0.75	0.75
Операторын ур чадварыг тооцох коэф		0.85	0.85
Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12	12.00
Ээлжийн цаг ашиглалтийн коэффициент	Кц	0.92	0.92
Экскаваторын ээлжийн бүтээл	м ³ /ээлж	913.3	1980.5
Хоног дах ээлжийн тоо	^э	2	2
Экскаваторын хоногийн бүтээл	м ³ /хоног	1826.5	3961.0
Жилд ажиллах хоног	хоног	30	30.00
Экскаваторын жилийн бүтээл	мян.м ³ /ж	54.8	118.8
Нийт ажлын хэмжээ	мян.м ³	112.0	207.9
Шаардлагатай экскаваторын тоо	ш	2.0	1.7

Уурхайн тээвэр

“Ододгоулд” ХХК -д сул зогсолттой байгаа 25-30 тн даац бүхий 18-20 м³ багтаамжтай 5 ширхэг Howo маркийн автосамосваль байна. Эдгээрийг тооцоогоор шалгаж үзэхэд уурхайн хамгийн өндөр ачаалалтай үед 5 ширхэг байхад хүрэлцээтэй байна.

Хүснэгт 9. Автосамосвалын бүтээл, хэрэгцээний тооцоо

Үзүүлэлт	Нэгж	Нowo
Автосамосвалын бүтээл	м ³ /ээлж	2536
Автосамосвалын мөчлөгийн хугацаа	сек	312.3
-Ачаалах хугацаа	сек	220.3
-Хөдөлгөөний хугацаа	сек	72.0
-Ачаа буулгах хугацаа	сек	20
Ээлжийн цаг ашиглалтын коэф	Кца	0.92
Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12
Автосамосвалын даац	тн	25-30
Операторын ур чадварыг тооцох коэф	-	0.85
Жилд ажиллах хоног	Хоног	30
Автосамосвалын жилийн бүтээл	мян.м ³ /жил	76.1
Ажлын хэмжээ	мян.м ³ /жил	319.9
Уурхайд шаардагдах автосамосвалын тоо	ш	4.2
Паркийн тоо	ш	5



Зураг 4. Автосамосвал

Овоолгын аж ахуй

Хөрсний овоолго. Уурхайн хөрс хуулалтын ажлыг экскаватор, автосамосвалын хослолоор гүйцэтгэж, хуулсан хоосон чулуулгийг олборлолтоос үүссэн хоосон орон зайд үе шаттайгаар дүүргэн дотоод овоолго үүсгэнэ. Ашиглалтын хугацаанд нийт 199.84 мян.м³ хөрс хуулалтын ажил гүйцэтгэнэ.

Шимт хөрсний овоолго. Шимт хөрсний овоолгыг ашиглалтын талбайн ойролцоо байгуулж, уурхай ашиглалт дууссаны дараа нөхөн сэргээлтийн хучилтад ашиглана. Уурхайлалтын талбайгаас үүсэх шимт хөрсний хэмжээ 199.17 мян.м³, тунгаагуурын сууриас 1.48 мян.м³, нийт 200.65 мян.м³ байна. Овоолгын ажилд экскаватор, автосамосвал, хутгуурт ачигч ажиллана.



Зураг 5. Хутгуурт ачигч

Баяжуулалтын технологийн тооцоо

Элс угаан баяжуулах цехийн технологийн тооцооны үр дүнгээс цехийн технологийн оновчтой горим, тоног төхөөрөмжийн хүчин чадал тэдгээрийн сонголт, технологид зарцуулах цэвэр болон эргэлтийн усны хэмжээ, бүтээгдэхүүн гаргалт, ажиллах хүчний тооцоо зэрэг баяжуулалтын чухал үзүүлэлт гардаг учир технологийн тооцоог оновчтой зөв тооцоолох нь маш чухал юм.

Элс угаан баяжуулах цехийн технологийн тооцоо

Элс угаан баяжуулах цехийн ашиглалтын жилүүдэд Улсын чанартай баяр ёслолын өдрүүд буюу наадмын 5 хоног амарна. Харин техник, тоног төхөөрөмжүүдэд үзлэг үйлчилгээ, урсгал засвар хийхээр сард 3 хоног байхаар төсөлд тусгалаа. Үйлдвэрийн ашиглалт эхний жил 5-р сарын 01-ээс, 2 дахь жил 6 -р сарын 01 -ээс эхэлнэ гэж ТЭЗҮ-д

ӨЛЗИЙТ ГОЛЫН ХҮЙТЭНИЙ АМНЫ ТОХОЙН ХЭСЭГ" НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫН
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ


тусгасан бид 2025 онд олборлолтыг хожим эхэлж төлөвлөгөөт олборлолтыг хийж чадаагүй тул 2026 онд 5-р сарыг 01-ээс эхэлнэ. Энэхүү хугацаа нь бэлтгэл ажил болон тоног төхөөрөмж суурилуулах ажлыг хугацааг оролцуулаагүй болно. Угаан баяжуулах үйлдвэрийн ажиллах горимыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 10. Баяжуулах хэсгийн технологийн ба ажлын горим

№	Үзүүлэлтүүд	Тоон утга
		2026 он
1	Жилийн хуанлийн өдрийн тоо	365
2	Жилийн хуанлийн сар	12
3	Жилийн хуанлийн цаг	8760
4	Өдрийн хуанлийн цаг	24
5	Цех ашиглалт, %	44.4
6	Өдөрт ажиллах бодит цаг	10
7	Сард ажиллах бодит цаг	270
8	Жилд ажиллах бодит цаг	1620
9	Жилд ажиллах бодит хоног	162
11	Цагийн хүчин чадал, м ³ /цаг	80.0
12	Хоногийн хүчин чадал, м ³ /хоног	800.0
13	Сарын хүчин чадал, м ³ /сар	21600

Элс угаах скрубберийн ээлжийн болон жилийн бүтээлийг “Бүтээлийн нэгдсэн норм” болон NZMS80BE маркийн скрубберийн техникийн үзүүлэлтэд тулгуурлан тооцоолсон болно. Тооцоогоор ээлжид 800.0-720 м³ элс угаан баяжуулахаар тооцоологдлоо.

Ашиглалтын үеийн үйлдвэрлэлийн нөөцийн тооцооноос эхний жилд 72.5 мян.м³ элс угаан баяжуулах ажилд 91 хоног, хоёр дахь жилд 23.75 мян.м³ элс угаан баяжуулах ажил 33 хоног тус тус үргэлжлэхэд дээрх угаах шаардлагатай элсийг бүрэн угааж дуусах буюу хүчин чадал нь хангалттай хүрэлцэх нь харагдаж байна.



Зураг 6. Алттай элсийг баяжуулах технологи

Тоо-чанарын схемийн тооцоогоор металл авалтыг 90.24%, алтны сорьцыг 890 гэж тооцоонд авлаа. Тус ордын алт агуулсан элсийг хоёр жилийн хугацаанд үйлдвэрлэх технологийн үзүүлэлтийг дараах байдлаар тооцоолов. Үүнд:

Ашиглалтын нөөцийн тооцооны дагуу элсэн дэх алтны дундаж агуулга эхний жилд 402.7 мг/м^3 , хоёр дахь жилд 356.7 мг/м^3 гэж авав.

Хүснэгт 11. Жилд гаргах бүтээгдэхүүний хэмжээ

№	Үйлдвэрлэлийн нөөц				Технологийн хэсэг		
	Элс мян.м ³	Дундаж агуулга, мг/м ³	Алт, кг.шлих	Алт, кг.х.ц	Металл авалт, %	Технологийн хаягдал, кг.х.ц	Бүтээгдэхүүний хэмжээ, кг.х.ц
1	72.5	407.2	29.2	26.36	90.24	2.56	23.46

Эндээс тус ордын хэмжээнд лабораторийн туршилтаар тогтоосон алтны сорьцыг 890.

Хаягдлын сан

Хаягдлын сангийн тооцоо. Тус ордын хаягдлын санг угаах төхөөрөмжийн дэргэд уурхайн ухаш дотор байгуулахаар төлөвлөв.

Хаягдлын сангийн байгууламж нь далан, хаалт, овоолго, эргэлтийн усан сан, ус цэвэрлэгээний байгууламж, пульпа насосын байгууламж зэрэг орно. Хаягдлын сан доорх нөхцөл шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Хүрээлэн буй байгаль орчин, олон нийтийн аюулгүй байдалд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх
- Ашиглалтын үед болон хаалтын дараа тогтвортой байдлаа хадгалах

- Үерийн болзошгүй аюулаас хамгаалагдсан байх
- Хаягдлын далан байгуулах зардал хямд байх
- Баяжуулах үйлдвэрийн ашиглалтын нийт хугацаанд гарах хаягдлыг багтаах хангалттай багтаамжтай байх
- Хаягдал тээвэрлэх зардал хямд байх
- Хаягдал тээвэрлэхтэй холбоотой хүрээлэн буй орчны сөрөг нөлөөлөл хамгийн бага байх зэрэг болно.

Далан нь элс хайргаар шавраар /хөрс хуулалтын шороо/ бүрдсэн овоолго байна. Далангийн бусад хэсгийг хайрга болон зориулалтын материалаар бэхжүүлж босгоно.

Технологийн зориулалтаар хэрэглэх цэвэр усны хэмжээг багасгах хаягдал усны хэмжээг бууруулах зорилгоор хаягдлын усыг эргүүлж ашигладаг. Баяжуулах хэсэгт алт агуулсан элсийг угаахдаа уурхайн ухашын шүүрлийн усыг ашиглах ба нийт хэрэгцээний 70%-г нь эргэлтийн усан сангаас хангагдах учир баяжуулах хэсгийн ойролцоо 375м³ багтаамжтай усан санг байгуулна. Энэхүү усан сан нь 3 хэсгээс бүрдэнэ. Эхний болон хоёр дахь усан сан нь баяжуулах хэсгээс ирж буй булингартай уснаас хатуу буюу хүнд хольцуудыг тунгаан авч үлдэх буюу цэвэр усыг шүүрүүлэх зориулалттай. Дараагийн усан сан нь баяжуулах хэсэг рүү буцаан шахах цэвэр усыг хуримтлуулах үүрэгтэй юм.

Хүснэгт 12. Хаягдлын сангийн үзүүлэлтүүд

	<i>Үзүүлэлт</i>	<i>Хэмжих нэгж</i>	<i>Бохирын нуурын</i>	<i>Эргэлтийн усан сан</i>
	Хаягдлын далангийн талбай	м ²	750	500
	Далангийн урт	метр	80	70
	Далангийн өргөн	метр	1	1
	Далангийн ажлын налуу	хэм	45	45
	Далангийн эсрэг налуу	хэм	45	45
	Далангийн өндөр	метр	0.5	0.75
	Хаягдлын цөөрмийн	м ³	375	375
	эзлэхүүн			

4. ТӨСЛИЙН ДЭД БҮТЭЦ

4.1. Уурхайн хотхон

“Ододгоулд” ХХК нь ажилчдын гэр орон сууцыг ажиллагсдын амьдрах түр орон сууцны зориулалтаар ашигладаг. Мөн хоолны газар, халуун ус, оффисын зориулалтын зөөврийн барилга, агуулахын контейнер, бие засах газар, биеийн тамирын талбай, засварын талбай, зогсоолын талбай г.м байгууламжуудыг байгуулсан. Уурхайн ажиллах хугацаа бага тул суурин байгууламж байгуулахгүй.



Зураг 7. Уурхайн хотхоны бүдүүвч зураг

ШТМ-ын агуулах

Шатахуун хадгалахад зориулж 8м³ ёмкость 1ш, бусад ШТМ-ыг зориулалтын савтай нь хадгална. ШТМ борлуулдаг компанитай байгуулсан гэрээний дагуу тогтсон хуваарийн дагуу уурхайд ШТМ-ыг хүргүүлнэ.

4.2. Холбооны байгууламж

Уурхайн тосгонд харилцаа холбооны хувьд МЦХ-ны үүрэн холбооны сүлжээтэй. Уурхайн оффис нь өндөр хурдны интернэтэд холбогдоно. Уурхайн тосгонд сансрын антенн суурилуулж телевизийн сувгууд хүлээн авч байна.

4.3. Цахилгаан хангамж

Уурхайн цахилгааны хэрэглэгч нь усны насос, угаах төхөөрөмж, гагнуурын аппарат болон гал тогоо, гэрэлтүүлэг г.м бусад жижиг хэрэглэгчид байна. Уурхайн ажиллах хугацаа богино, цахилгаан эх үүсвэр байхгүй уурхайн цахилгааны хэрэгцээг дизель станцаар хангаж байна.

Баяжуулах хэсэг нь тосгоноос 0.6-1.6 км зайд байрлана. Баяжуулах хэсгийн цахилгаан хангамжийг 70 кВт-н КС70 дизель станцаар хангана. Уурхайн тосгон болон засварын хэсгийн цахилгаан хангамжийг 20 квт-ын кс20 дизель генератораар хангана.

4.4. Усан хангамж

Ил уурхайн ус таталт

Ашиглалт явуулах талбайн хувьд дөрөвдөгчийн бэл, хормойн гаралтай сэвсгэр хурдас дахь жигд бус тархалттай газрын доорх ус оршино. Өлзийт голын ус агуулагч хурдас нь элс, хайрга, хайрганцар найрлагатай байх ба татмын хэсэгтээ 1.8-2.0 м гүнд жигд түвшингээр уст давхара илэрнэ.

Энэ хэсэгт усны ундарга нь 4.0 л/сек байдаг нь сүүлийн 20 жилийн ажиглалтаар тогтоогдсон бөгөөд усны хатуулаг нь 2.7 мг.эқв/л юм. Уурхайн шүүрлийн усыг баяжуулах төхөөрөмжийн хэрэглээнд хэрэглэнэ.

4.5. Технологийн усны хэрэгцээний тооцоо

Баяжуулах үйлдвэрийг хоногт дунджаар 800 м³ элсийг угаана гэж үзвэл хоногт 2128м³ ус зарцуулна. Баяжуулах төхөөрөмжийн хаягдал усны бүрэлдэхүүнд хаягдал булингар, шүүлтүүрийн шүүгдэс болон үйлдвэрийн машин, тоног төхөөрөмжийн цэвэрлэгээний бохир ус зэрэг багтана. Технологийн зориулалтаар хэрэглэгдэх цэвэр усны хэмжээг багасгах, хаягдах усны хэмжээг бууруулах зорилгоор түүнийг эргүүлэн ашиглахаар тооцов.

Уурхайд шүүрэн орж байгаа ус нь баяжуулалтын бохир усан дахь бохирын агууламжийг бууруулахад нэмэр болохоос гадна баяжуулалтын усан хангамжийн гол эх үүсвэр болно. Уулархаг, гол горхитой хэсэгт усыг их хэмжээгээр хуримтлуулан олон дахин эргүүлэн ашиглах нь ус хэмнэж байгаа мэт харагдах боловч эцсийн дүнд агуулах нуур цөөрмийн асуудлаас болж голд нийлүүлэхээс өөр аргагүйд хүрдэг. Энэ үед ус нь маш нарийн ширхэг бүхий олон дахин угаагдсан тунадас хэлбэрийн зуурмаг болон хувирсан байдаг. Энэхүү зуурмаг нь гол руу орсноор голын ёроолыг бүрхэн, урсгалд цохиулж дэгдсээр олон өдөр сараар голыг бохир урсахад хүргэдэг. Иймд усыг аль болох ойр ойрхон юулж байна.

Хүснэгт 13. Технологийн усны хэрэгцээ

он	Элсний хэмжээ, м ³	Усны норм, м ³ /м ³	Усны хэрэглээ, м ³	Эх үүсвэр			Усны төлбөр, төг	
				Эргэлт	Шүүрлээр	Голоос	Нэгжийн үнэ, төг	Нийт үнэ, сая төг
2026	75860.0	2.66	201787.6	141251.3	60536.3			

4.6. Уурхайн усан хангамж

Баяжуулах үйлдвэрийн технологийн усыг уурхайн шүүрлийн болон эргэлтийн усаар хангахаар төлөвлөсөн. Нийт усны хэрэглээ 201787.6м³/жил бөгөөд үүнээс 141251.3 м³ (70%)-ийг уурхайн эргэлтийн усаар, 60536.3м³ (30%)-ийг нөхөн сэлбэлтийн усаар хангана. Шаардлагатай тохиолдолд нэмэлт усны эх үүсвэрийг Өлзийт голоос татаж ашиглах боломжтой.

Баяжуулах үйлдвэрийн усан хангамжид БНХАУ-д үйлдвэрлэсэн 150м³/цаг хүчин чадалтай 4РМА маркын насос 2ш Өлзийт голоос ус татах болон баяжуулах төхөөрөмж тэжээхэд ашиглахаар төлөвлөлөө.

Унд ахуйн усыг уурхайн тосгонд гаргасан 0.2л/с ундаргатай худгаас хангана.

5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай шинэчилсэн хуулийн 9-р зүйлд зааснаар байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийн хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан

баримт бичиг бөгөөд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-ний салшгүй хэсэг мөн.

БОМТ -ний бүрдэл хэсэг, агуулга

БОНХАЖЯ-ний Сайдын тушаалаар баталсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалд дараах зүйлийг оруулахаар тусгасан байна.

Байгаль хамгаалах төлөвлөгөө:

Байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, сөрөг үр дагаврыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө, химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, нөхөн сэргээлт, орчны тохижуулалтын (явцын) төлөвлөгөө, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө, түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох төрийн байгууллага, олон нийтэд тайлагнах төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүний нөөц, байгаль орчны удирдлагын бүтэц зохион байгуулалтын схем, газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын төслийн хувьд биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, уул уурхайн төслийн хувьд хаалтын зорилт, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө орно.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр:

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, сөрөг нөлөөллийн болон үр дагаврын тархалтын хүрээнд нөлөөллийг хэмжих хэмжигдэхүүн, үзүүлэлтүүдийг тодорхойлж, тухайн орчноос дээж, сорьц авах, хэмжилт хийх, түүнд дүн шинжилгээ хийх арга, байршил, хугацаа, шинжилгээ хийх давтамж, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгана.

Хүснэгт 14. БОМТ-ний бүрдэл хэсэг, агуулга

	БОМТ-ний бүрдэл хэсэг	Агуулга
	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ БОМТ-г хэрэгжүүлэх удирдлагын тогтолцоог ажиллуулах, бэхжүүлэх, хөгжүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах Байгалийн баялаг, нөөц ашигласны төлбөр, хураамж Сургалт, мэдээллийн үйл ажиллагаа Газар, байгалийн нөөц ашиглалт, хэмнэлт, хамгаалалт, хяналт-шинжилгээ, Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, журам
	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Байгаль орчны тэнцлийг хангах зорилгоор байгалийн баялаг ашигласан газар, орчныг засаж сайжруулах, тохижуулах, ховордсон амьтан, ургамлын ашиглалтыг хязгаарлах, үржүүлэх, нутагшуулах, тэжээлээр хангах зэргээр нөөцийг нь нэмэгдүүлэх; Байгаль орчны нөхөн сэргээлтийн стандарт, заавар, журмыг хэрэгжүүлэх арга хэмжээ

**ӨЛЗИЙТ ГОЛЫН ХҮЙТЭНИЙ АМНЫ ТОХОЙН ХЭСЭГ" НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫН
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Биологийн олон янз байдлыг хамгаалах, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, үр дүнг тайлагнах хэлбэр, хяналт тавих механизм
	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	Сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, оршин суугчид, айл өрхийн бүртгэл, судалгаа Нөхөн олговрын арга хэмжээ, шинэ газарт нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын зардал
	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Төсөл хэрэгжих бүс нутагт хийсэн археологийн судалгаа, түүх соёлын өвийн судалгааны дүн, соёлын өв дурсгалуудын талаарх нутгийн иргэд, байгууллагын мэдээлэлд үндэслэн түүх соёлын өв дурсгалыг хамгаалах
	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	Байгалийн гамшиг түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ, химийн бодисын эрсдэлийн үнэлгээний дүнд тогтоогдсон аюултай болон хортой химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, шаардагдах зардал
	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	Хог хаягдлын тухай хууль, стандартыг хэрэгжүүлэх хатуу, шингэн, хийн хаягдлыг багасгах, зайлуулах, устгах арга хэмжээ
	ТЖБОМТ-г хэрэгжүүлэх Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	Байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх механизм, байгаль орчны бодлого, удирдлагын зохион байгуулалт
	ТЖБОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	БОМТ-ний хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох төрийн байгууллага, олон нийт, нутгийн ард иргэдэд мэдээлэх, тайлагнах Төслийн үйл ажиллагаатай холбоотой гарсан санал, шүүмжлэлийн хариу арга хэмжээ, гомдол барагдуулах үйл ажиллагаа
0	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Нөлөөлөлд өртөж болзошгүй байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгмийн төлөв байдлын суурь мэдээлэл ба төсөл хэрэгжсэнээр түүнд гарч болзошгүй тоон ба чанарын өөрчлөлт; Нөлөөллийг багасгах, арилгах, нөхөн сэргээх, хоргүйжүүлэх, саармагжуулах арга хэмжээний үр дүнг хэмжих тоон ба чанарын үзүүлэлтүүд; Төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Монгол улсын хууль тогтоомж, стандарт болон хэм хэмжээний үзүүлэлтүүд; Хяналт-шинжилгээ хийх шаардлагатай байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээнүүд, нөлөөллийг хэмжих хэмжигдэхүүн; Сорьц авах, хэмжилт хийх, түүнд дүн шинжилгээ хийх арга, байршил, хугацаа, давтамж;

5.1. БОМТ хэрэгжүүлэх удирдлагын тогтолцоо

Аливаа байгууллагын байгаль орчны асуудлыг хариуцах, удирдан зохион байгуулах бүтэц нь 180 14001 2004 (МК8 2006) стандартад заасан Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ) бөгөөд үүнд тухайн байгууллагын байгаль орчны бодлогын хүрээнд төлөвлөх-хэрэгжүүлэх-хянах-шийдэх гэсэн 4 үйл ажиллагаа тасралтгүй хийгдэж байгаль орчны үзүүлэлт байнга сайжирч байх нөхцөлийг бүрдүүлдэг. Менежментийн тогтолцоонд байгууллагын бүтэц, төлөвлөлт, хариуцлага, практик үйл ажиллагаа, бодлого, дүрэм журмын баримт бичиг, процесс, нөөцийг хамааруулдаг (180 14001, 2004).

БОУТ-ний бүрдэл хэсэг, үйл ажиллагааны товч тайлбар:

1. **Байгаль орчны бодлого:** Тухайн байгууллагын байгаль орчны үзүүлэлтийн талаар дээд удирдлагаас тогтоосон зорилт, чиглэл юм.

2. **төлөвлөлт:** Байгаль орчны асуудал, хууль журам, стандартын шаардлага, байгаль орчны талаар баримтжуулж, баталгаажуулсан зорилго, зорилт, хөтөлбөр;

3. **Хэрэгжүүлэлт:** Хүн, материал, технологи, дэд бүтэц, санхүүгийн нөөц,

үүрэг, хариуцлага, захиргаа, ажиллагсдын мэдлэг чадвар, сургалт, харилцаа холбоо, байгаль орчны баримт бичиг болон үйл ажиллагааны хяналт, удирдлага, онцгой нөхцлийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах ажиллагаа;

4. **Хяналт, сайжруулалт:** Хяналт шинжилгээ, хэмжилт, гүйцэтгэлийн шалгалт, дутагдал, доголдлыг засах, сайжруулах, сэргийлэх, бүртгэлийн хяналт удирдлага, дотоод аудит;

5. **Удирдлагын хяналт:** Байгууллагын дээд удирдлагын зүгээс тогтмол хугацаанд хийх хяналт шалгалтын үйл ажиллагаа, байгаль орчны бодлогын хэрэгжилт, гүйцэтгэлийн үзүүлэлт, үр дүнг хянаана.

5.2 БОМТ-ний хэрэгжилтийн хяналт

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаар БОМТ-ний хэрэгжилтийн хяналт дараах байдлаар хийгдэнэ:

1. БО-ний нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хүлээн авч дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батална (заалт 9.8).

2. Ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагаанаас бусад төрлийн төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тус сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнах ёстой (заалт 9.9).

3. БОМТ-ний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, БО-ний хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны ТББ хяналт тавина (заалт 9.12).

Шаардлагатай тохиолдолд БО-ний нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын шийдвэрээр БОМТ-ний хэрэгжилтэнд хөндлөнгийн хяналт хийж, дүгнэлт гаргах бөгөөд уг ажилд шаардагдах зардлыг төсөл хэрэгжүүлэгч хариуцна (заалт 9.13).

4. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага БОМТ-ний биелэлтийн тайлан болон энэ хуулийн 9.12, 9.13-т заасан хяналтын дүнг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчийн баталгааны мөнгийг буцаан олгох эсэх асуудлыг тусгай журмын дагуу шийдвэрлэнэ (заалт 9.14).

5. Байгаль орчны аудитыг 2 жилд нэг удаа мэргэжлийн байгууллагаар хийлгэх,

5.3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 15. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Агаарын чанар	Хуурайшилт ихтэй үед 5-10 дугаар сард өдөрт 2-оос доошгүй удаа усалгаа хийж тоосжилтыг бууруулна.	Уурхайн орчимд	мян.төг	400.0	1	400.0	Төлөвлөгөөт онд	Агаарын чанарын үзүүлэлт МН84585:98
2	Гадаргын ба газрын доорхи усны нөөц	Борооны ус цуглуулах нуур болон эргэлтийн усны нуур байгуулж тодорхой хэмжээнд гадаргын усны хэрэглээг багасгана.	Уурхайн орчимд	Мян.төг	1000.0	1	1000.0	Төлөвлөгөөт онд	Усны тухай хууль тогтоомжууд
3	Хөрсөн бүрхэвч	Техникийн нөхөн сэргээлт хийгдсэн 7.8 га талбайд нутгийн унаган олон наст ургамлын үрийг нормын дагуу цацаж биологийн нөхөн сэргээлт хийнэ.	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд	Мян.төг	300	1	300.0	Төлөвлөгөөт онд	
4	Газрын хэвлий	Уурхайн дотоод хөдөлгөөнийг батлагдсан маршрутаар явуулж, шинээр ул мөр гаргахыг хориглон, тэмдэг тэмдэглэгээг улирал бүр шинэчилнэ	Уурхайн орчимд	Мян.төг	400.0	1	400.0	Төлөвлөгөөт онд	
5	Амьтны аймаг	Амьтдын дайжин шилжилт, үүр, ичээ, усан цэг орчимд техник хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлаж, шөнийн цагийн шаардлагагүй хөдөлгөөнийг багасгана	-	-	-	-	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан		
Нийт				мян.төг			2100.0		

5.4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 16. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Техникийн нөхөн сэргээлт	Олборлолт дууссан ухашийг дотоод овоолгоор дүүргэж, налууг тогтворжуулан, талбайг тэгшлэх	га	7.8	-	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	Төлөвлөгөөт онд, олборлолтын явцтай уялдуулан	MNS 5917:2008, БОННУ-2025
2	Биологийн нөхөн сэргээлт	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд шимт хөрсөөр хучиж, нуггийн унаган олон наст ургамлын үр цацах	га	7.8	2,000,000	15,600,000	Төлөвлөгөөт онд	MNS 5917:2008, БОННУ-2025

5.5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 17. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
№	1	2	3	4	5	6	7	8
1	Олборлолт дууссан ухашийг дотоод овоолгоор дүүргэж, налууг тогтворжуулан, талбайг тэгшлэх	Тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах эвдэрсэн хэсэгт техникийн хэлбэржүүлэлт, тэгшилгээ, шимт хөрсөөр хучилт, биологийн нөхөн сэргээлт хийх	ТЗ талбайд хамаарах болон ойролцоо эвдэрсэн хэсэг	1 багц	9,200,000	9,200,000	Төлөвлөгөөт онд	БОННУ-2025, Байгаль орчныг хамгаалах тухай хууль

Тайлбар: Тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах, гар аргаар ашигт малтмал олборлогчдын эвдэрсэн 1 га талбайд техникийн хэлбэржүүлэлт, тэгшилгээ, шимт хөрсөөр хучилт, биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн.

Хүснэгт 18. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ төлөвлөсөн булангийн цэг

№	Өргөрөг	Уртраг
1	46° 25' 28.300"	99° 28' 21.900"
2	46° 25' 23.240"	99° 28' 22.031"
3	46° 25' 23.182"	99° 28' 19.042"
4	46° 25' 26.409"	99° 28' 18.979"
5	46° 25' 28.700"	99° 28' 19.400"

5.6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд талбайд түүх, соёлын дурсгалт зүйл, газрын гадаргад ил харагдах археологийн олдвор байхгүй. Гэсэн хэдий ч төслийн үйл ажиллагааны явцад газрын хэвлийгээс археологи, палеонтологийн дурсгал илэрч болзошгүй тул нийт ажилчид, жолооч нарт анхааруулга сануулга өгч, хэрвээ түүх, археологийн дурсгалт зүйл илэрвэл ажлаа нэн даруй зогсоож сумын удирдлага, цагдаагийн байгууллагад мэдэгдэн, эрдэм шинжилгээний байгууллагад хандах нь зүйтэй.

Харин Археологийн хүрээлэнгийн судалгааны 2017 онд явуулсан судалгааны ажлын үр дүнд тус лицензийн талбайн хажуугийн талбайд 26 тооны дурсгалыг олж илрүүлэн баримтжуулсан байна. Төсөл хэрэгжүүлэгч нь Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар бүлгийн 7.10, 17.12 заалтууд болон холбогдох журмын дагуу боловсруулсан.

Хүснэгт 19. Түүх-археологийн дурсгалын хадгалалт хамгаалалт

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Археологийн дурсгал илэрч болзошгүй	Газрын ажил эхлэхийн өмнө ажилчдад зааварчилгаа өгөх, олдвор илэрвэл ажлыг нэн даруй зогсоох, хамгаалалтын бүс тогтоох, сум, цагдаа болон мэргэжлийн байгууллагад мэдэгдэх	Уурхайн олборлолтын болон дэд бүтцийн талбай	1 багц	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	-	Төлөвлөгөөт онд, тогтмол	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
2	Палеонтологийн олдвор илэрч болзошгүй	Газрын хэвлийгээс яс, чулуужсан үлдэгдэл, олдвор илэрсэн тохиолдолд	Уурхайн талбай	1 багц	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	-	Төлөвлөгөөт онд, тогтмол	Соёлын өвийг хамгаалах тухай хууль,

**ӨЛЗИЙТ ГОЛЫН ХҮЙТЭНИЙ АМНЫ ТОХОЙН ХЭСЭГ" НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫН
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	тухайн хэсгийн ажлыг зогсоож, хамгаалалт авч, холбогдох байгууллагад яаралтай мэдэгдэх							БОННУ-2025
--	--	--	--	--	--	--	--	------------

Газрын хэвлийгээс археологи, палеонтологи, түүх соёлын шинжтэй олдвор илэрсэн тохиолдолд тухайн хэсгийн ажлыг нэн даруй зогсоож, хамгаалалтын бүс тогтоон, сумын удирдлага, цагдаагийн байгууллага болон холбогдох мэргэжлийн байгууллагад 24 цагийн дотор мэдэгдэнэ.

5.7. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Төслийн 2026 оны ашиглалтын үйл ажиллагаанд баяжуулалтын болон олборлолтын технологид химийн урвалж, тэсрэх болон хорт аюултай химийн бодис ашиглахгүй.

Гэсэн хэдий ч уурхайн хэвийн үйл ажиллагаанд дизель түлш, тос тосолгооны материал, аккумулятор, шүүр, тосон алчуур зэрэг химийн шинж чанартай болон аюултай хаягдал үүсгэх боломжтой материалыг ашиглах тул тэдгээртэй холбоотой эрсдэлийг бууруулах менежментийн арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- шатах тослох материалыг зориулалтын сав, агуулахад хадгалах,
- асгаралт, алдагдлаас сэргийлж битүүмжлэл, бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгах,
- засвар үйлчилгээний талбайд тос, шатахуун асгарсан тохиолдолд нэн даруй саармагжуулах, цэвэрлэх,
- тос, тосолгооны материалын сав, бохир шүүр, аккумулятор, шүүлтүүр зэрэг аюултай хог хаягдлыг тусгай тэмдэглэгээтэй, битүүмжилсэн саванд ангилан хадгалж, эрх бүхий байгууллагад шилжүүлэх,
- ажиллагсад шатах тослох материалтай аюулгүй харьцах, асгаралтын үед авах арга хэмжээний талаар зааварчилгаа өгөх,
- галын аюулгүй байдлын багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажиллах болно.

Химийн бодис ашиглахгүй боловч шатах тослох материал, аюултай хаягдалтай холбоотой эрсдэлийг уурхайн дотоод хяналт, ХАБЭА болон байгаль орчны хяналтын хүрээнд тогтмол хянаж, зөрчил илэрсэн тохиолдолд тухай бүр арилгуулна.

5.8. Хог хаягдлын менежмент

Хүснэгт 20. Хог хаягдлын төрөл, хэмжээ, устгах хэлбэр

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хатуу хог хаягдал	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, тусгай зориулалтын саванд цуглуулан сумын төвлөрсөн цэгт гэрээний дагуу хүргэж зайлуулах	Уурхайн тосгон	мян.төг	1,000	1	1,000,000	Төлөвлөгөөт онд	Хог хаягдлын тухай хууль

**ӨЛЗИЙТ ГОЛЫН ХҮЙТЭНИЙ АМНЫ ТОХОЙН ХЭСЭГ" НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫН
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2	Үйлдвэрлэлийн хог хаягдал	Үйлдвэрлэлийн хаягдлыг зориулалтын цэгт түр хадгалж, боломжтойг дахин ашиглах, үлдсэнийг журмын дагуу зайлуулах	Уулын хэсэг, баяжуулах хэсэг	мян.т өг	1,000	1	1,000,000	Төлөвлөгөөт онд	Хог хаягдлын тухай хууль, БОННУ-2025
3	Аюултай хог хаягдал	Тос, тосолгооны материалын сав, бохир шүүр, аккумулятор, шүүлтүүр зэрэг аюултай хаягдлыг тэмдэглэгээтэй битүүмжилсэн саванд хадгалж, эрх бүхий байгууллагад шилжүүлэх	Засварын талбай, агуулах	мян.т өг	-	1	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	Төлөвлөгөөт онд	Аюултай хог хаягдлын журам
Нийт				2,000,000					

Хатуу хог хаягдал: Алтны шороон ордыг ашиглах үед үүсэх үйлдвэрийн хог хаягдлыг уурхайн нөхөн дүүргэлтэд ашиглах бөгөөд ахуйн хог хаягдлыг хадгалах, зайлуулах менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа. Алтны шороон ордын ашиглалтын үед өдөрт 19кг, сард 0,5тн, жилд 3,2тн, ашиглалтын хугацаанд 5.5тн ахуйн хатуу хог хаягдал гарна. Үүсэх ахуйн хог хаягдлыг тусгай зориулалтын саванд цуглуулж, Бөмбөгөр сумын захиргаатай байгуулсан гэрээний үндсэн дээр зайлуулж булшилна.

Уул уурхайн үйл ажиллагааны явцад үүсэх аюултай хог хаягдлыг Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль болон холбогдох дүрэм, журмын дагуу эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, стандарт шаардлага хангасан түр хадгалах байгууламжид хадгална. Түр хадгалсан аюултай хог хаягдлыг эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид гэрээний үндсэн дээр шилжүүлж, аюулгүй тээвэрлэлт, устгал, дахин боловсруулалтыг гүйцэтгүүлнэ. Аюултай хог хаягдлын үүсэлт, хадгалалт, шилжилт хөдөлгөөний бүртгэлийг тогтмол хөтөлж, холбогдох байгууллагад тайлагнана. Мөн уул уурхайн үйл ажиллагаанаас үүсэх аюултай хог хаягдлын төрөл, хэмжээ, менежментийн талаарх мэдээллийг орон нутгийн иргэдэд хагас жил тутам ил тод хүргэнэ.

Шингэн хог хаягдал: Алт угаах үйл ажиллагаанаас гарсан шингэн хаягдлыг тунгаах нуурт тунгааж дахин ашиглах бөгөөд уурхайн ашиглалтын дараа хатаах, зайлуулах аргаар устгана. Харин ажилчдын ахуйн шингэн хаягдлыг уурхайн орчимд байгуулсан түр жорлонд (тусгайлан бэлтгэсэн, хөрс усанд ахуйн бохир алдагдахааргүй доторлосон, агааржуулагч, нян устгагч, үнэр дарагчаар тоногдсон) хадгалах, тогтмол хугацаанд соруулж хаях, эсвэл ашиглалтын дараа булшлах арга хэмжээ авна. Ашиглалтын явцад 19 ажилтан албан хаагч байнга уурхай дээр байна гэж үзвэл өдөрт 0.3 тонн, сард 9тн, ашиглалтын хугацаанд 79.8 тн ахуйн шингэн хог хаягдал гарна. Бохир усны нүхийг зориулалтын дагуу хийж гүйцэлтгүйгээс ус хөрсөнд нэвчих, улмаар газрын доорх усны чанарт нөлөө үзүүлэх аюултай.

Аюултай хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн дагуу эх үүсвэр дээр түр хадгалж, зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид шилжүүлнэ.

Орон нутгийн иргэдэд уул уурхайн үйл ажиллагаанаас үүсэх аюултай хог хаягдлын талаар хагас жил тутам мэдээлэл өгнө.

5.9. БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 21. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв /мян.төг/	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1	БОМТ-ийг уурхайн удирдлага, инженер техникийн ажилтан, нийт ажиллагсад танилцуулах, дотоод сургалт зохион байгуулах	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	2026 оны 5 сар	Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн, уурхайн дарга	БОМТ-ийн хэрэгжилтийн зорилт, арга хэмжээ, хариуцлагыг танилцуулна
2	Ажиллагсад байгаль орчныг хамгаалах, хог хаягдлыг ангилан ялгах, ус, хөрс бохирдуулахгүй байх талаар зааварчилгаа өгөх		2026 оны 5-10 сар, сар бүр	Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн, ХАБЭА ажилтан	Шинээр ирсэн болон ээлжийн ажилтнуудад давтан зааварчилгаа өгнө
3	Уурхайн дотоод үйл ажиллагаанд байгаль орчны хяналт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах, биелэлтэд хяналт тавих		2026 оны 5-10 сар, сар бүр	Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн, уурхайн инженер	Дотоод хяналтын бүртгэл хөтөлж, зөрчлийг хугацаатай арилгуулна
4	Орон нутгийн удирдлага, баг, сумын холбогдох албан тушаалтанд төслийн хэрэгжилт, БОМТ-ийн явцын талаар мэдээлэл хүргэх, уулзалт зохион байгуулах		2026 оны 6 сар, 9 сар	Уурхайн дарга, байгаль орчин хариуцсан мэргэжилтэн	Оролцогч талуудтай харилцах, санал хүсэлт авах
5	Орчны хяналт-шинжилгээ, нөхөн сэргээлт, усалгаа, хог хаягдлын менежментийн хэрэгжилтийн тайланг нэгтгэх		2026 оны 10-11 сар	Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн	Хяналт-шинжилгээний үр дүн, хэрэгжилтийн тайлан боловсруулна
6	Жилийн эцсийн БОМТ-ийн хэрэгжилтийн тайлан боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх		2026 оны 11-12 сар	Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн, уурхайн дарга	Дараа оны БОМТ боловсруулах суурь мэдээлэл болно

5.10. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Төслийн үйл ажиллагаанаас агаар, ус, хөрс, ургамал, амьтанд үзүүлэх нөлөөллийг илрүүлэх, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт, сөрөг нөлөөллийг бууруулах талаар авсан арга хэмжээний дүнг хянаж шалгах, цаашдын үйл ажиллагааг тодотгох зорилгоор

**ӨЛЗИЙТ ГОЛЫН ХҮЙТЭНИЙ АМНЫ ТОХОЙН ХЭСЭГ" НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫН
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. ОХШХ-ийг хэрэгжүүлэхэд жилд 2.000.0 мян. төгрөг зарцуулахаар төсөвлөв.

Хүснэгт 22. Орчны хяналт шинжилгээний ажлын төсвийн тооцоо

№	Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	Хөрсний чанар, нефтийн бүтээгдэхүүний бохирдол, эвдрэлийн байдал	Уурхайн талбай, шимт хөрсний овоолго, хяналтын цэг	Төлөвлөгөөт онд 2 удаа	2	300,000	600,000	Нөхөн сэргээлт, хөрсний бохирдлын хяналт	БОННУ-2025, холбогдох MNS стандарт
2	Усны чанар, булингар, рН, ерөнхий хатуулаг, шүүрлийн усны нөлөөлөл	Голын дээд ба доод цэг, шүүрлийн ус, усан сан	Төлөвлөгөөт онд 2 удаа	2	300,000	600,000	Гадаргын болон технологийн усны нөлөөллийг хянаана	Усны чанарын стандарт, БОННУ-2025
3	Агаарын чанар, нийт тоос, PM, SO2, NO2	Уурхайн дотоод зам, баяжуулах хэсэг, ажилчдын байр орчим	Төлөвлөгөөт онд 2 удаа	2	400,000	800,000	Тоосжилт болон агаарт үзүүлэх нөлөөллийг хянаана	Агаарын чанарын стандарт, БОННУ-2025
Нийт					2,000,000			

Орчны хяналт шинжилгээний: Төслийн үйл ажиллагааны явцад төлөвлөгдөөгүй судалгаа, хяналт-шинжилгээний ажлууд гарч ирэхийг үгүйсгэх аргагүй юм. Төслийн байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт зардал, түүний хуваарилалтыг Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаж өгсөн ба жил бүр шинэчлэн тооцож байх шаардлагатай болно.

5.11. Тэрбум мод тарих арга хэмжээ

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд хүрээнд төслийн хүрээнд орон нутагт жил бүр 1000 мод тарихаар төлөвлөсөн бөгөөд мод тарих зардлыг үйл ажиллагааны зардалд тусгасан болно.

Мод тарих заавар

Тарихаар сонгон авсан мод, сөөгийг үрслэгийн талбайд болон бортоогоор ургуулж байгаа тохиолдолд шууд шилжүүлэн суулгана. Суулгацыг тээвэрлэхдээ анхаарах зүйл бол үндсийг хатахгүй байх явдал юм.3-4 настай суулгацыг 50-70 ширхгээр нь багцлан боогоод үндсийг хар шорооны нойтон зуурмагт дүрж бэхжүүлээд түүнийгээ нийлэг альсаар 2-3 давхар боож хамгаалж тээвэрлэнэ. Модны суулгацыг тарихын өмнө багцаас задлан үндсийг бүтнээр нь нойтон шороогоор булж түр хадгална. Модыг тарихдаа хавар IV.15-V.05-ны хооронд, намар IX.20-X.10-ны хооронд тарихад тохиромжтой. Бид намар болон хавар 500, 500ш мод тарихаар төлөвлөсөн.

Модны нүх ухаж бэлтгэх

Мод тарих талбайд модны нүхийг ухаж бэлтгэхдээ 0.7-0.8 метрийн голчтой, 0.5-0.6 метрийн гүнтэй нүхийг ухаж бэлтгэнэ.Ухсан нүхнээс гарсан хөрс, шорооны байдлыг

харгалзан нүхний 50 хувь нь үржил шимт хар шороон хөрс, хөх бууц 10 орчим кг-ыг нэмэн хийж сайтар хутгаж тэгшилж орхино. Ухсан нүхнээс гарсан үржил шимгүй буюу хайргыг зөөж зайлуулан оронд нь хар шороон хөрсөөр бэлтгэн тавина. Энэ нь мод суулгах үед нэмэлт болон чийгжүүлэхэд хэрэглэгдэнэ. Хуучин шороог болж өгвөл хэрэглэхгүй байх нь чухал. Учир нь хуучин бохир, үржил шимгүй, бүтэц алдагдсан шороо нь суулгацын үндэсний цааш ургах, хөгжихөд хангалттай шим тэжээл өгч чаддаггүй. Модны нүх ухсан газар нь хөрсний сүвэрхэг чанар муутай, ус барих чадваргүй бүтэцтэй бол нүхний ёроолыг шар шавраар өнгөцхөн шавардаж өгч болох ба үндсэн хөрсийг бүрэн солих шаардлагатай.

Бут сөөгний нүх ухаж бэлтгэх

Таригдах төрөл бүрийн бут сөөгний нүх 50-60 см гүн, 40-50 см голчтой байна. Нүхэнд хийх шороо нь шим тэжээл сайтай хар шороон хөрс байх ба ухсан нүхнээс гарсан шороог ашиглах боломжтой бол (чулуу хайргагүй, эсвэл хэт шаварлаг биш) дангаар нь эсвэл дээр нь 2-4 кг хөх бууц, 75-100 гр фосфорын бордоо нэмж сайтар хольж хэрэглэнэ. Ургамлан хашлага тарих шуудуу нь 50 см өргөн, 50 см гүнтэй байна. Шуудуунд хийх шорооны хэмжээ шуудууны 75 хувьд тэнцэх хэмжээтэй байна. Ухсан шуудуунаас гарсан шороог ашиглах боломжтой бол хар шороо, бууц, эрдэс бордоог дээрх хэмжээгээр хольж сайжруулсан хэлбэрээр ашиглах бөгөөд дан хар шороо ашиглаж болно. Ер нь олон жил талхлагдсан, хөрсний үржил шим бүхий давхаргагүй болсон, хог болон бусад зүйлээр их бага хэмжээгээр бохирлогдсон хөрсийг шинэ тарилтанд ашиглахгүй байх нь зүйтэй.

Нэгэнт бэлтгэж бэлэн болгосон нүх, шуудуугаа тарилт хийхийн өмнөх өдөр 1-2 удаагийн давтамжаар ханатал нь усалж өгнө. Энэ нь хөрсний чийгийн багтаамжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Хүснэгт 23. БОМТ-ийн нийт зардлын тооцоо

№	Төлөвлөгөө / арга хэмжээ	2026 онд хийх ажил	Хугацаа	Зардал /мян.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоосжилт бууруулах усалгаа, усны менежмент, газрын хэвлий ба хөдөлгөөний маршрут мөрдүүлэх, амьтны аймагт сөрөг нөлөө багасгах	2026 оны ашиглалтын хугацаанд	2,100.00
2	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	7.8 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт	2026 он	15,600.00
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Эвдэрсэн талбайд техникийн хэлбэршүүлэлт, тэгшилгээ, шимт хөрсөөр хучилт, биологийн нөхөн сэргээлт	2026 он	9,200.00
4	Түүх, соёлын өвийг хамгаалах	Олдвор илэрвэл ажил зогсоох, хамгаалалтын бүс тогтоох, холбогдох байгууллагад мэдэгдэх	Тогтмол	-
5	Хог хаягдлын менежмент	Ахуйн, үйлдвэрлэлийн, аюултай хог хаягдлыг ангилан ялгах, хадгалах, эрх бүхий байгууллагаар зайлуулах	2026 он	2,000.00
6	Удирдлага зохион байгуулалт	БОМТ танилцуулах, дотоод сургалт, сар бүрийн хяналт, орон нутгийн мэдээлэл солилцоо, жилийн тайлан	2026 он	-
7	Орчны хяналт-шинжилгээ	Хөрс, ус, агаарын хяналт-шинжилгээ	2026 он	2,000.00
8	Тайлагнал	БОМТ-ийн хэрэгжилтийн тайланг жилийн эцэст хүргүүлэх	2026 оны 11-12 сар	-
Нийт				30900